



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/87

Хэрлэн сум

Эмнэлгийн машин худалдан авах
ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5, 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2, 50.3, 50.4, 50.5 дахь хэсүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих Эмнэлгийн машин худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Б.Дарханбаатар	Хууль эрх зүйн хэлтсийн дарга
Нарийн бичиг:	Н.Үнэнбат	Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүн:	Ц.Бат-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Оюун	Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Х.Гонгор	Иргэний төлөөлөл

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Дарханбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ